

18

ДУРСАМЖ БА БОДРОЛ

Л.Дамбадорж



Төрсөн нутгаасаа алсханд

Намайг арвандөрвөн нас хүрэх үе хүртэл манайх дандаа л ганц гэрээр байдаг байснаас би хүн таньдаггүй, хааяа хүн тааралдаад юм асуухад нь дуугарч зүрхлэдэггүй нөхөр байлаа. Тэгээд 1946 онд төрсөн нутагтаа ирж бага сургуульд орсоноор үнэхээр хүмүүсийн дунд орсон доо. 1946 оны зунаас өмнөх үед бол би үнэндээ л хөдөөний зэлүүд нутгийн нэгэн “маугли” байж дээ гэж боддог юм. Ийнхүү олон нөхөдийн дэмжлэг түшигт орж эрдэм ухааны зах зухаас мэдэж мэргэжил эзэмшээд ажил төрөл хийж байгаад

“нягтлан бодох бүртгэл”-ийн багш олон шавьтай, түүний дотор олон арван эрдэмтэн шавьтай болоод өдий зэрэгт хүрч яваадаа туйлаас баяртай байна.

Арвайхээрийн хүрээнд шавилан сууж асан Түндэв гэдэг гавж лам “цаг цөвүүн” болохыг зөнгөөрөө мэдэрч ардын хувьсгалын дараахан 60 давсан настайдаа Арвайхээрийн хошуундаа буюу Гучин-Ус сумынхаа хөдөөд очиж ядруу бүсгүйтэй гэрлэж, олон хүүхэдтэй ядуу ард Луузангийнхаас хоёр хүүг нь үрчлэн авч аж төрж байгаад 1937 оны өвөл баривчлагдан хөнөөгджээ. Хөвгүүдийнх нь том нь 1927 онд төрсөн Цэрэндорж, бага нь 1933 онд төрсөн Дамбадорж би юм. Бид хоёр бол аав, ээжээсээ төрсөн арван гурав дахь ба арван тав дахь хөвгүүд аж. Ламыг баривчлан аваачсанаас хойш бид гэртээ гурвуул үлдэж.

Тэгээд биднийг үрчилсэн эхийн төрсөн ах Лодов гуай зэргэлдээ Ховд сумын нэг багийн санитарч хийж байхдаа 1938 оны зун манайхыг нүүлгэн Арцын өвөр рүү аваачиж хаяагаа бараадуулжээ. Лодов гуайг Баянхонгор аймагт (тэр үед Өвөрхангай, Архангай, Баянхонгор нь Цэцэрлэг Мандал гэсэн нэг аймаг байсан гэдэг) ажиллуулахаар томилоход Цэрэндорж ах минь тэднийхтэй хамт явчихсан ба удалгүй ардын цэрэгт явсан аж. Тэднийх нүүсэн үе нь 1940 он юм уу түүнээс арай өмнө үе байх гэж бодном. Үрчилсэн эх бид хоёр Ховд сумын төвөөс холгүйхэн ганц

гэрээрээ л, хэдхэн бог мал, арваад тэмээтэй айл байдаг байв. Цаг ямагт ганц гэрээр, айл хунараас алсад байх учраас би үе тэнгийнхэнтэйгээ ер уулздаггүй, малын бэлчээрт ч хүн амьтантай тааралддаггүй байж билээ. Тиймээс 5 наснаасаа 14 хүртлээ Ховд суманд арваад жил байж өсөж бойжсон ч нэг удаа айлсаж өвөлжсөн Сангидорж гуайн хүү Түндэвдамбаа, үрчилсэн эхийг өнгөрсөн хойно хаяанд нь буулгасан Дондовын Нацагдорж гэсэн хоёрхон л бандитай танилцаж нэрийг нь мэддэг болж байсан байх юм.

Нэг зун үрчилсэн эхийг нас барахад Ховд сумын дарга Дэмчигдорж гуай гэдэг хүн мэдэж сумын төвөөс хүмүүс ирүүлж өөд болоочийг хөдөөлүүлүүлээд намайг сумын төвийн дэргэд хөсөг сахьдаг малгүй, ядуу айл Дондов гуайн хаяанд буулгаж билээ. Би хэдэн хонь ямаагаа Тэвш ууланд хариулж, хадны сүг зураг харсаар, ягшил модны навч мөчир сонирхсоор л явах. Тэр айлын авгай хэдэн ямаа сааж сүү хөөрүүлж надад өгдөг байв. Нэг өдөр хэдэн ямаагаа саалгахаар дөхүүлж иртэл манай гэрийн гадаа алсаас ирсэн байлтай тохомтой тэмээ уяатай байх аж. Нэг л сайхан юм болох нь гэж бодсоноос уу, түргэхэн гүйсээр гэрт орвол миний эгч Дулам гэдэг хүн намайг аваачихаар ирсэн байв. Намайг өнчрөн хоцорсоныг Ховд сумын дарга Дэмчигдорж гуай Гучин-Ус сумын захиргаанд мэдэгдсэн юм байж. Тэр үеийн хүмүүс, ялангуяа Ховд сумынхан үнэхээр хүн сайтай улс байж дээ. Манай сум руу хэл хүргүүлээгүй бол би гэдэг амьтан яах байсан бол оо!

Ядуу айлан ганц хүүхэд гэснээс үү, эсвэл сумын өрхийн тоонд манайх ороогүй байсан уу, намайг Ховдын сургуульд суулгана энэ тэр гэдэггүй л байсан юм. Тэр үед Маршал Чойбалсан Ховд суманд ирж гэнэ, дайн дажин болж байгаа, “жармаан” (герман), “шатаалан” (Сталин), “гяатлаар” (Гитлер), “ёвкоон” (япон), “пороомтонд” (фронтод) морь бэлэглэсэн, бич жилийн зуданд малаа нэлээд хороолоо, их борооны жил энэ Ховдын голоор хүн амьтан гарч чадахгүй боогдож олон хонож байсан, Бага Богд уулнаас нэг тарвага бууж (хужир мараа авахаар говь руу) ирэхэд нь өвчтэй байх гэж их айж сандарцгаасан, Зүүнбогдын хүрээг буулгаж байна гэнэ, тэр гуайг тээр жил бариад явсанаас хойш сураг тасарсан гэнэ, Ховд сумыг Төхөм рүү нүүлгэлээ гэхчлэн хүмүүс ярьдаг байсны учир начирыг нь олохгүй ч гэсэн санаанд тодхон үлдсэн байх ажээ.

Төрүүлсэн эцэг, эхийгээ би нэг л удаа харсан байв. Уг нь Богд сумнаас Гучин-Усын 3-р баг буюу манай нутгийг хүрэхэд ихээр бодоход 50-иад километр орчим зайтай юм билээ л дээ. Тэр үед хүн бүлгүй айлын хүүхэд, чавганц хоёр тэр “хол” зайг яаж туулж барах вэ дээ.

Тэр үеийн Ховд сум нь 1957 оны шиг санагдана, газар хөдлөлтийн гамшигийн дараа Зүүн богд сумтайгаа нийлээд Богд сум болсон аж. Богд суманд өсөж бойжсоныг минь тэр сумын зарим хүмүүс мэдээд намайг Богд сумны хүн гэдэг юм. Өвөрхангайн Богд сум бол Бага Богд, Арц Богд, Их Бага Баян, Булган хайрхан, Сэрвэн, Тэвш, Шийр хайрхан, Ухаа хайрхан гээд сайхан сайхан уултай, булаг даац ихтэй сайхан нутаг даа. Хэлмэгдлээс болж нүүж очоод, хожим нь орь ганцаар үлдээд төрсөн нутгаа бараадсан ч гэсэн Богд сумын нутгийг би төрсөн газар шороо лугаа адил бодож, өсөх наснаасаа бараа сүрийг нь харсаар нүднээ дасал болж

сэтгэлд хоногшсон сайхан уулсыг нь бишрэн бодож, уул хайрхануудад нь залбирч явдаг юм. Тэгээд ч бидний эцэг дээр үед Арвайхээрийн нутгаасаа хааяа алслан нүүж Гурвансайхан уулын ар, Арц Богдын өвөр хоолойгоор олонтаа нутаглаж зээр, хулан, хавтгай ангуучилж хэдэн хүүхдээ тэжээдэг байсан юм гэнэлээ. Одоо үед манай төрөл садан нараас Самдан ахын хүүхдүүдээс эхлээд “Цагаан бөө” удмынхан гэгдэх нэлээд хэдэн айл Богд суманд шилжиж нутагшсан байна лээ.

Аз түшиж бага сургуульд оров Эгч маань намайг төрсөн гэрт минь нүүлгэж аваачлаа. Бидний эцэг өнгөрсөн жил (1945 онд) бурхан болсон гэнэ. Манайх гэдэг айлд ээж Лагсам, эгч Дулам, ах Самдан, Дулам эгчийн Цэенпил, Бүд гэдэг хоёр охин ийм ам бүл дээр би нэмэгдэж зургуулаа боллоо. Манайх хэдхэн бог мал, хэдэн тэмээ, чөдрийн хэдэн морьтой, ийм л ядмагхан айл аж. “Чи одоо 14 нас хүрчээ, мөдхөн цэрэгт явчихна. Та нарын том ах Бууч хүү хорь шахам жилийн өмнө цэрэгт яваад сураггүй болсон. Үхсэн амьдыг бүү мэд. Самдан ах чинь ирэх жил цэрэгт явна. Одоо мөдхөн тооллого болох нь. Эгчийн чинь том охин сургуульд сууж байгаа, дүү нь бас мөдхөн сургуульд орно. Тиймээс чамайг 12 настай гэж тоолуулна. 12 настай хүүхдийг сургуульд хөөхгүй биз. Цэрэгт явтлаа чи төрсөн гэр ормондоо хэдэн жил байж бидэнд туслаж байх нь дээр” гэж ээж хэлж байв. Тэр үед жил бүрийн 8-р сарын 1-нд мал, хүн амын тооллого болдог журамтай байж. Нэг өдөр хүмүүс ирж тооллоо. Дарга нь Дамбадаржаа гуай гэнэ. Тэр тооллогод ээж намайг 12 настайгаар бүртгүүлснээр Гучин-Ус сумын хүн амын дансанд орж билээ. Ховдод байхад манайхыг тоолдог байсан эсэхийг санадаггүй билээ.

Намар болж эгчийн хүүхэд ч сургуульдаа явчихлаа, манайх говь руугаа нүүлээ. Тэр үед 9 дүгээр сар барагцаж байсан байх. Тооллогоор манай багт ирж байсан Дамбадаржаа дарга нэг өдрийн үдийн хэрд манайд хүрээд ирлээ. Нэгдүгээр ангид суулгах хүүхдийн тоо гүйцээгүй учир 9-өөс 12 насны бүх хүүхдийг сургуульд суулга гэж аймаг, сумын захиргаадаас өгсөн заавал биелүүлэх даалгавраар яваа гэнэ. Намайг сургуульд суулгах гэж тэр хүн ээж, эгч хоёртой баахан ярьж, ятгаж, ухуулаад дийлэхгүй болоод ирэхээрээ албаны ажил саатуулсан гэж торгоно, Самдан хүүг чинь “албадан ажилд явуулна” энэ тэр гэж “айлган сүрдүүлж” байгаад намайг саахалт айлын хүүхдийн хамт тэр орой нь сумын төв рүү хүргүүлэхээр явуулж билээ. Хүүхдийн тоо гүйцээгүй байснаас нэгдүгээр ангийн хичээл эхлээгүй байлаа.

Тэгсээр нэгдүгээр ангийнханд зориулж ширээ сандалгүй, модон шалгүй бор гэр хоёрыг барьж, хуучин дээвэр, цавагны эсгийгээр хийсэн дэвсгэр дээр биднийг цомцойлгон суулгаад ном зааж эхэлсэн ба бидний зарим нь олдсон цаасан дээр, зарим нь “үнсэн самбар” (тостой хөө түрхсэн модон дээр үзүүрлэсэн модоор бичээд, түүнийгээ арилгахдаа үнс түрхчихдэг байв) гээч дээр бичдэг байлаа. Дайны дараах үе учраас эхний үед цаас, харандаа их ховор байснаа дараахан нь их элбэг болж байв. Ингэж л би анх удаа сумынхаа төвийг үзэж, анх удаагаа “А” үсэг заалгаж, сургуульд ийм олон хүүхэд сурдагийг бас л анх удаагаа мэдэв.

Шинэ үг хэллэгийг ойлгоход хэцүү байв. Багш орж ирээд самбарын дээд хэсэгт тоо, үсэг биччихээд “амсар тавиарай!” гэх шиг болох.

Ходоодны буюу шавианы амсар, аяганы амсар гэдэг шиг самбарын дээд ирмэгээр бичсэнийг бас “амсар” гэдэг юм байж гэж бодоод л бид хоорондоо “амсар” гэлцдэг байсансан. Тэр нь одоогийнхоор “огноо” юм байж. Ийнхүү он, сар, өдөр гэж байдгийг, долоо хоногийн өдөр нь тус тусдаа нэртэй байдгийг бас л анх удаа мэдсэн л дээ. Ийнхүү элчилгүй говьд биш ч гэсэн айл хунараас зайдуу өссөн би бага сургуулийн буянаар хүмүүсийн дунд орж, олон хүүхэдтэй танил болох үе эхэлсэн тэр жил нь 1946 он гэдгийг мэдсэн билээ.

Ээж минь ядуугийн улмаас, тэгээд бас Түндэв гавж гуайг “багш” гэж хүндлэн шүтдэгийн улмаас тэднийд өргүүлсэн отгон хүү намайгаа хүрч ирэхэд нь хэдэн жил ч гэсэн дэргэдээ байлгах гэж 12-той болгож тоолуулаагүй бол, Гучин-Ус сумын бага сургуульд 14 настай намайг тэр Дамбадаржаа гуай “баривчилгаагаар” аваачиж суулгаагүй бол миний хувь тавилан ямар болж хаашаа эргэх байсныг өнөө үед төсөөлөхөд бэрх. Тэр дарга ажил үүргээ биелүүлэхийн төлөө махран зүтгэж, хүмүүсийг ятгаж, болохгүй бол айлгахаас буцаагүй байсанд нь би тэр Дамбадаржаа гуайг насан туршдаа үнэхээр бахдан дурсаж яваа хүн.

1950 онд бага сургууль төгсөхөд намайг Өвөрхангайн 10 жилийн дунд сургуульд ороорой гэж Самданцоодол багш минь захиж хэлж байсан боловч ээж, эгч хэмээх “хоёр мундагчуул” маань огт хэрэгсээгүй учир хэдэн малын хойноос явсаар, хүн бүлгүй айлуудад зарцлагдсаар 1952 оны намар хүргэсэн билээ. Тэр үед Самдан ах цэргээс халагдаж ирсэн байлаа. Өвөрхангайн Хоршоодын холбоонд алба хашиж байсан Сангидорж ах минь намайг сургууль, курсэд явуулах гэж ээж, эгч хоёртой олон удаа “хэлцэл” хийсэн боловч огт бүтдэггүй сэдэв нь байж билээ. Миний хувьд бол цэрэгт нь явчихсан гэж бодохын зэрэгцээ сургууль, курс гээчид нь ч орохсон л гэж боддог байлаа. Энэ бол тэр үеийн залуу хүмүүс “хөмөрсөн тогоо”-ноос гарахаар зүтгэж эхэлсэн үе байв.

Нягтлан болох эхлэл Тэгтэл Сангидорж ах минь нэгэн “онцгой” арга олж тэр намар намайг аймгийн төвд аваачиж чадсан юм. Ах маань “Цаадуул чинь эртхэн ирүүлсэнсэн бол чамайг сургуульд явуулах байлаа. Би өнөө маргаашгүй хөдөө сум руу явах томилолт авсан. Иймээс чи эндээ байж бай. Буцаад харих л юм бол ээж чамайг нааш нь дахиад ирүүлэхгүй шүү. Ирэх жил техникумд явуулна” гэж байв. Тэгээд намайг Хоршоодын холбоонд “данс хөтлөгч-дагалдан сурагч” хэмээх огт байгаагүй цоо шинэ орон тоо “бодож олоод” Өлзийт гуай гэдэг нэртэй төртэй, шилдэг сайн даргаараа тушаал гаргуулсны дагуу би тэр газарт 1952 оны 12-р сарын 9-нөөс 1953 оны 8-р сарын 20 хүртэлх хугацаанд ажиллаж орос сампинд нэмэх, хасах үйлдэл бодож, барааны орлого зарлагын баримт шалгаж, инкасс, вексел бичиж сурсансан.

Бас болоогүй ээ, 120 төгрөгийн цалин авна. Хавар нь Ховд, Зүүнбогд, Гучин-Ус сумдын хоршоодод хүргэх мал, ноосны мөнгө гэж боодолтой тавтын дэвсгэрт хорин мянган төгрөгийг банкнаас авч шуудайнд хийгээд шуудангийн машины тэвшин дээр олон хүмүүсийн дунд шидчихээд, замын айлд ороход нь даган орж тараг уусаар явж зуур хоноод аваачиж өгч байж билээ. Алдчихна гэж айх аюулгүй л байж. Өлзийт гуай нэг удаа ажилтан нарынхаа хийж буй ажилтай танилцаж

явсанаа миний бичсэнийг хараад “Сайн нягтлан болох хүү байна” гэхэд нь би их урамшиж байж билээ. Хүмүүнд үгээр урам хайрлах гэдэг энэ л байж дээ.

Анхны хоршооны нягтлан болов Сангидорж ах маань Өмнөговьд Хоршоодын холбооны нягтлангаар томилогдож 1953 оны зун явахдаа “Энэ нөхрийг Хоршооны техникумд энэ намар явуулаарай” гэж найз нартаа захиж байлаа. Тэр ёсоор Өвөрхангайн Хоршоодын холбооныхон намайг Улаанбаатар руу явуулж, би ч Хоршооны техникумд орж гурван жил суралцав. Техникумд ирсэний хойно нэг эцэг эхээс төрмөл, нэг айлын өргөмөл Цэрэндорж ахтайгаа учран золгож халамж энэрэлд нь орж билээ, Техникумаа 1956 онд төгсөөд Хоршоодын Төв Холбооны хуваарилснаар Дундговь аймагт очлоо.

Намайг Дэлгэрхангай сумын анхны хоршооны нягтлан болгов. Цалин их гэж тоймгүй (эхлээд 275 төгрөг, дараа нь 400 төгрөг болж байсан нь хөдөө газартаа том цалин байлаа). Дэлгэрхангайд очоод Л.Тогтох гуай гэдэг айлд суув. Тэднийх намайг төрсөн хүү шигээ л байлгах, тэгээд авгай нь намайг “манай хүү бол!” гэх. Би бол “хүний хүү хүрэн бөөртэй” гэгчээр сургуульд орохсон л гэж бодох, тэгээд л эхний үед нь гадаадад сургуульд явахсан гэж бодоод тоо бодлого, орос хэл, бас англи хэл оролдох, дараа нь Эдийн засгийн дээд сургуульд байгуулагдахад нь тэнд л орохсон гэж мөрөөдөж аймгийн хоршоодын холбоо, аймгийн гүйцэтгэх захиргаа, намын хороо, Хоршоодын төв холбоо (хожим Худалдаа бэлтгэлийн яам болсон) зэрэг аль байгаа дээд газрууддаа жил бүр өргөдөл бичээд л байх. “Ажлаа сайн хийж бай!” гэсэн хариу ХБЯ-наас ирэх, бусад нь таг чиг л байх.

Дээд сургуульд орох аз таарав Тэгсээр ЗХУ-д сургуульд явах аз таарч 1960 оны 7-р сарын 29-нд Дэлгэрхангай сумын худалдаа бэлтгэлийн ангиас (өмнө нь анхны хоршоо гэж байсан) халагдаж Худалдаа бэлтгэлийн яамны дуудлагаар хүрч ирэв. Элсэлтийн шалгалт аваад аль эрт дуусчихсан аж. Чамаас элсэлтийн шалгалт авна л гэж байна. Тэгээд эрүүл мэндийн үзлэгээ түргэн дуусгаад ир гэхээр нь эмнэлгүүдээр явган гүйсээр, шалгалтанд таарах болов уу гэж тоо бодох аядсаар байтал арав гаруй хоног өнгөрчихөж.

Үзлэгт орж гүйцээд эрүүл мэндийн хуудсаа ХБЯ-ны боловсон хүчний газарт өгвөл Баянзул гэдэг залуу надаар өргөдөл бичүүлж 1500 төгрөг өгөөд “Тавын халуун усны тэнд гаргасан дэлгүүрээс хувцас хунар ав” гэж байна. Шалгалт авахаа больсон бололтой. Шалгалт авах уу гэж би ч асуусангүй. Тэр их мөнгөнөөс зарж жаал зугаа юм авч явахад тэр дэлгүүрт дуугүй кинонд харсан Янжмаа гуай (Сүхбаатар жанжины гэргий) нэг охинд бас хувцас юм авч өгч байж билээ. ХБЯ-ны нэр дээр хэсэг нөхдийн хамт ЗХУ-д явах боллоо. ХБЯ-ны нэр дээр явах залуусаас нэгийг нь ч танихгүй юм даа. Би Эрхүүд очих юм байна. Эрхүүгийн Санхүү-эдийн засгийн дээд сургуулийн нягтлангийн ангид Сангийн яамны хуваариар арав гаруй нөхөд очсон бөгөөд биднийг хоёр бүлэгт хуваахад би Ц.Баянбат гэдэг залуутай цуг нэг бүлэгт нь үлдэв.

1961 оны намар Ч.Дашсамбуу ирж бүлэгтээ гурван монгол болов. Багш нарын хэлж байгааг бид хагас дутуу бичдэг, хальт мультхан ярих

аяддаг болоод байсан үе буюу 1961 оны хавар цаг. Нэг өдөр хоёрдахь лекцийн завсарлагаа болоод хонгилд гарцгаалаа. Баянбат маань тамхилгааны өрөө рүү явсан байж. Би ганцаараа оросуудын дэргэд зогсож байтал орос нөхөд маань гэнэт л дэвхцэж цовхчоод, орилолдож хашгиралдаад л учир тоймгүй сүртэй юм боллоо. Юу болж байгааг яаж ийгээд асуувал өнөөдөр, 1961 оны 4-р сарын 12-нд ЗХУ-ын иргэн Ю.А.Гагарин сансарт ниссэн байна гэв. Тэгээд л ийн баярлан бахдаж байгаа нь энэ аж. Би ч гэсэн баярлаж байна. Хоршооны техникумд байсан үеэ саналаа. Жаргалантын сангийн ахуйд явж ажилласан 23 эрэгтэй хүүхдийг нэг анги болгосон нь манай анги байлаа.

Нэг хавар манай ангийн багш Б.Дэндэв (хожим гавъяат багш болсон) маань нэгэн өглөө ангид орж ирээд “За хүүхдүүдээ, баяртай мэдээ дуулгая! Сансарт хүн ниссэн байна!” гэхээр нь бид босоцгоогоод өөрсдөө сансарт нисчихсэн юм шиг баярлан хөөрцөглөцгөөж орилолдож чарлалдаад л шал дэвслэж пичигнээн нажигнаан болоод явчихсан чинь багш маань “Дөрвөн сарын нэгэн гэж мэдэх үү, та нар” гэв. Бидний урам хугарч, чимээ авиагүй болж байж билээ. Тэр өдөр 4-р сарын 1 байж л дээ. Ийнхүү хэдэн жилийн өмнө болсон дөрвөн сарын нэгний “хуурамбай” биелэлээ сая олж сансарт хүн ниссэн тэр өдөр орос нөхдийн хамт байсандаа баярлаж байсансан.

Төрөлх техникум минь МУИС-д ирэх зам нээлээ Эрхүүгийн Санхүү-эдийн засгийн дээд сургуульд 4.5 жил суралцаж 1964 оны 11-р сард дүүргээд ирэхдээ ХБЯам намайг аль нэг хөдөөд нягтлангаар явуулах байх гэж бодож байтал Худалдааны техникумд багшлах томилолт өгөхөд нь нэгд, нийслэл хотод суух болсондоо, *хоёрт*, Хоршооны техникум гэж байхад нь суралцаж төгссөн төрөлх сургуульдаа, надад хичээл зааж байсан багш нарынхаа өмөг түшигт орж багшлах болсондоо би их баярлаж байлаа.

Эрхүүд байхдаа Гадаад хэлний багшийн дээд сургууль төгсөж байхад нь танилцаж гэр бүл болсон хань маань ч Якутдаа 5 жил ажиллаад хүрч ирлээ, хүүхэдтэй ч боллоо, Худалдааны техникумын буянаар орон сууцанд ч орлоо. Ингээд би Худалдааны техникумдаа 1964 оны 11-р сарын 9-ноос эхлэн нягтлангийн багшаар 6 жилийн хугацаанд ажиллаад МУИС-д 1970 оны 2-р сарын 1-нд шилжин ирж өнөөг хүртэл нягтлангийн хичээл заасаар байгаа. Ийнхүү МУИС-д шилжиж ирсэн нь ангийн нөхөр Дашсамбуу маань намайг “хичээл заачихмаар нэг нөхөр Худалдааны техникумд багшилж байгаа” гэж тэнхимийнхээ эрхлэгчид хэлдэг байснаас үүдэлтэй ажээ. Их сургуульд ажиллаад их юм үзлээ, олон сайн нөхөдтэй боллоо.

Хэд хэдэн сурах бичиг бичлээ, тэрчлэн “Essentials of accounting” (“Нягтлан бодох бүртгэлийн үндэс”) хэмээх алдартай сурах бичгийг англи-монголоор хадмаллан орчуулснаас гадна эдийн засгийн нэр томъёо, үг хэллэгийн 150-иад мянган үгтэй “The Most Up-To-Date English-Russian-Mongolian Dictionary” (“Орчин үеийн англи-орос-монгол толь”) бичиг зохиож хэвлүүлээ. Тэтгэвэрт гараад удаж байгаа боловч надад хэдэн цагийн хичээл заах боломж олгож дэм тус өгсөөр буй тэнхимийн эрхлэгч, эрдэмтэн профессор Сайнжаргалдаа, тэнхимийнхээ хамт олонд гүнээ

талархаж явдаг нэгэн бол би билээ. Охин Болормаа минь германд явуулах хүүхдүүдийн бэлтгэл ангид сураад БНАГУ-д очиж суралцаад төгсөх жилд нь “Берлиний хана” нурж, социалист системийн дээд боловсролыг барууныхан хараахан “тоож үздэггүй” учир Боннын Их сургуульд очиж суралцан дүүргээд Герман улсад ажиллаж байгаа.

Тэндээ сайн ханьтай, элэгсэг сайхан хадмуудтай болсоон. Эртнээс алдартай Боннын Их сургуулийг дүүргэсэн анхны монгол хүн нь бидний охин мөн байх гэж бодохоор л бахархал төрдөг юм даа. Эхнэр Инна маань 1961 оноос эхлэн Якутын Алдан, 1965 оноос Улаанбаатарын Барилгын техникум, 1981 оноос МУИС-д одоо хүртэл багшилсаар олон сайн шавьтай, олон сайхан багш нартай ижил дасал болжээ. МУИС-д намайг шилжиж ирэхэд манай сургуулийн хоёрдахь захирал буюу Б.Ширэндэв гуайн дараа болсон Д.Цэгмид гуай байсан бөгөөд дараа дараад нь захирал болсон Н.Содном гуай, Ж.Батмөнх гуай, О.Шагдарсүрэн гуай, Д.Дорж гуай, Ц.Ганцог гуай нарын удирдлага доор олон багш нарын хамт ажиллаж ирлээ.

Худалдааны техникум, МУИС-д ажиллах хугацаандаа оюутан, багш нарын хамт сангийн аж ахуй, хөдөө аж ахуйн нэгдэлд жил бүр явж хашаа хороо барих, төмс тариа хураах, өвс хадах, барилга барих, хотын сантехникийн шугам сүлжээний газар ухах, зүлэг суулгах, мод тарих ажил, хог ба цас цэвэрлэх, үерийн хамгаалалтын далан байгуулах ажил хийлцэж, баяр ёслолын болон гадаадын хүндэт зочид угтах жагсаал, цуглаан зэрэгт олон удаа оролцож байсансан. Харин түймэр унтраалгад явж байсангүй. Тэр үед түймэр хааяа нэгхэн гаргадаг л байсан байх.

Ийм байдлаар төрөлх эх орныхоо бүтээн байгуулалтын болон залуучуудад мэргэжлийн мэдлэг эзэмшүүлэх ажилд гар бие, санаа сэтгэлээрээ оролцож олон багш нарынхаа дэмжлэгээр, олон оюутан сурагчдынхаа буянаар өдий хүрч явнаа. Оролдлого багатай зарим оюутныг хараад миний “хөөрхөн ааш” хөдлөх тал байдаг. Тэгээд “Сурч мэдсэнийг чинь та нараас хэн ч, хэзээ ч булаагаад юм уу хулгайлаад авчихгүй шүү!”, “Тэгэж хэлдэг юм уу, ингэж бичдэг юм уу!” гэхчлэн жаахан дөвчигнөж байснаа тайвширч “Та нар надаас өөр багшаар ингэж загнуулж үзсэн үү?” гэж асуухад “Үгүй шүү, багш аа!” гэхээр нь сэтгэл зовдог юмаа.

Оюутан залуус гэж мөн ч сайхан сэтгэлтэй олон түмэн шүү. Төгсөөд ажиллаж байгаа оюутнуудаас зарим нь тааралдаад бид нар таны даалгаврыг хугацаанд нь гүйцэлдүүлж чадахгүй болохоороо “Маргааш хичээлд очиход Дамбаа үхсэн байгаасай!” гэлцдэг байж билээ гэж хөөр хөгжөөн болцгоох нь элбэг. Эх орондоо дээд мэргэжлийн эдийн засагч бэлтгэж эхэлсний 60 жилийн ойн номд өгсөн дурсамжиндаа зарим нөхөд миний тухай энэ маягийн утгатай зүйл бичсэн байгааг үзээд “Хүүхдүүд ийм л илэн далангүй сайхан улс даа!” гэж үнэхээр сэтгэл уярч, баярлаж явдаг нэгэн билээ, би.

Нас дээр гарсан энэ үед эргэн харвал аав, ээжээс цувж төрсөн арван таваас үлдсэн ах, эгч есөн хүмүүс маань хамгийн бага намайгаа гэхээ болиод олон сайхан үр хүүхэд, ач, зээ, гучаа үлдээгээд бурханы орондоо заларцгаачихсан байх аж. Тэр олон үр хүүхдүүдээс, тэд нарынх нь үр удмаас, ер нь бидний аав, ээжийн удам угсааныханаас хэн нь ч, хэзээ ч

хэрэг төвөгт орооцолдоогүй, төв түвшин, эвтэй найртай байцгааж шударга хөдөлмөрөөрөө аж төрсөөр, хөгшчүүлээ харж хандаж, халамжлан дэмжсээр байдаг нь өвгөн би сэтгэл хангалуун явдаг юм.

Багшилж байгаагийн буян, хамт олны дэмжлэгээр худалдаа, ардын боловсрол, санхүү-банк, бүртгэл-статистик, шинжлэх ухаан гэсэн таван салбарын тэргүүний ажилтан, таван удаагийн ойн медаль, Засгийн газрын жуух, Хөдөлмөрийн хүндэт медаль, Алтан гадас одон, хэд хэдэн газрын өргөжлөл, үүн дотор МУИС-ийн болон ЭЗС-ийн хүндэт профессор зэрэг олон өргөмжлөл, алдаршуулал хүртсэний дээр гавъяат багш хэмээх эрхэм хүндтэй цолоор Их Эзэн Чингис хаан Монгол улсынхаа тулгар төрийг үндэслэн байгуулсаны 800 жилийн ойн жилийн шувтрага үеэр шагнуулав.

Энэ нь манай тэнхимийн хувьд Ч.Түмэн багшийн удаахь нь, нягтлангийн багш нар дотроос Ю.Балжинням багш, Ж.Нямсүрэн багш нарын дараах буюу дөрөвдэх нь аж. Нягтлангийн мэргэжлийг залууст эзэмшүүлэх гэж олон багш нарын хамт зүтгэж ирсэний томоохон өгөөж нь энэхүү “Гавъяат багш” хэмээх алдар болой. Манай Нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн болон манай бусад тэнхимүүдийн багш нараас төрийн дээд шагнал хүртэх даваанд ихэд ойртсон нөхөд олон буй. Миний энэ шагнал “Булган сүүлтэй байх болтугай!” хэмээн ерөөх минь!

Ийнхүү 14 нас хүртлээ “А” үсэг мэдэхгүй явсан би Гучин-Ус сумын бага сургууль (4 жил), Хоршооны техникум (3 жил), Эрхүүгийн Санхүү-эдийн засгийн дээд сургууль (4 жил хагас) ийм гурван сайхан сургуульд сурч төгссөн ба Өвөрхангайн хоршоодын холбоо (9 сар), Дундговийн Дэлгэрхангай сумын анхны хоршоо (4 жил гаруй), Худалдааны техникум (6 жил гаруй), МУИС (37 жил) ийм дөрвөн том бөгөөд үнэхээр сайхан газарт ганцхан нягтлангийн мэргэжлээрээ ажиллаж байгаа хүн л дээ. Нягтлан бодогч мэргэжил үнэхээр сайхан ажил, сайхан мэргэжил шүү. Орчин үед энэ мэргэжил дэлхий даяарт нэр хүнд нь өсөж, нийгмийн захиалгаарх хэрэгцээ нь ахиж, хариуцлага нь улам ихэссэн байна.

“Их сургууль”, “Оюунтан” гэж анх сонсоод гайхаж л байлаа. Эдийн засгийн дээд мэргэжил эзэмшихээр эх орондоо суралцаагүй боловч МУИС-ийнхаа эдийн засгийн салбарт 40 шахам жил багшилж ирсэний хувьд дээд мэргэжлийн эдийн засагчдыг манай оронд бэлтгэж эхэлсний 60 жилийн ойг тохиолгон тэртээ 61 жилийн өмнө “Их сургууль” гэж гайхамшигтай том сургууль байдаг тухай сонсож байсан хөдөөний хүүхэд үеийн дурсамж бичиж байгаадаа сонин ч юм шиг, бахдам ч юм шиг санагдаж буйгаа хэлэх юун.

1950 оны хавар буюу МУИС байгуулагдаад наймдах жилдээ хичээллэж байсан, тэгэхдээ дээд мэргэжлийн эдийн засагч бэлтгэх ажил ор сураггүй байсан үед миний бие Өвөрхангай аймгийн Гучин-Ус сумын бага сургуулийг тэр хавар төгсөөд хөдөөнөө харьсансан. Манайх мал цөөтэй, ам бүл олуулаа. Иймээс нутгийн хүн бүл муутай хэн нэг нь манайд ирж ээжтэй ярьж байгаад л надаар мал хариулгана гээд аваад явдаг байлаа. Ийнхүү би 1950 оны зунаас эхлэн айл айлд зарцлагдан хонь, адуу, тэмээг нь хариулах, түлээний заг бэлдэх, нэхий элдэх, эмнэг хангал тором ба

даага сургах, айлын өвлийн идэш хийлцэх зэргээр гурван жил “хөдөө хөрч, гадаа гандаж” явсан хүн.

Ингэж малын дэргэд гурван жилийн нүүр үзэхдээ миний хувьд соёлжиж боловсорсон зүйл гэвэл хааяа нэгхэн сонины тасархай харагдвал гал ноцоочихоос нь өмнө өрсөж уншиж байснаас гадна азаар олдсон “Алтайд” туужийг уншсан, бас “Арван таван наст капитан” хэмээх Жюл Вернийн зохиолыг босоо монгол бичгээр Москва хотноо хэвлэснийг бидний садангийн нэг өвгөн ах надад өгөхөөр нь малын бэлчээрт явахдаа үсэглэж түгдчин оролдон оролдсоор байж сайн ойлгоогүй ч гэсэн “чадан ядан уншихсан” билээ. Тэр номыг уншсаны ачаар би монгол бичгээр хэвлэсэн номыг, багахан татлагатай гар бичмэлийг ч уншихдаг болж байлаа.

Тэгтэл аймгийн хоршоодын холбоонд байцаагч-нягтлан хэмээх алба хашиж байсан ах Сангидорж минь намайг татаж авах, нягтлангийн курсэд юм уу хоршооны техникумд явуулах гэж хоёр жилийн турш оролдсоор байж 1952 оны 8 дугаар сард арайхийж намайг аймгийн төвд аваачиж чадсансан. Ээж минь намайг хол явуулах дургүй байсны гол учир нь дээр үед, хориод оны хавьд юм уу даа, ууган хүү нь буюу бидний их ах цэрэгт яваад сураг тасарсан юм гэнэ лээ, бас тэгээд би гэдэг хүн отгон хүү нь байж. Аймагт хүрч иртэл ах маань 8-р сарын 1-нд болдог мал тооллогын ажлаар хөдөө явчихсан тул намайг тэр намар сургууль, курсэд явуулж завдсангүй.

Тэгээд 1952 оны 12 дугаар сараас Өвөрхангайн хоршоодын холбоонд 120 төгрөгийн цалинтай данс хөтлөгч-дагалдан сурагч хэмээх ажилд оруулж билээ. Ийнхүү анх удаагаа алба хашиж эхэлсэн минь, анх удаагаа ажлын хөлсөнд мөнгө төгрөг авах болсон минь энэ. Телефон утас, бичгийн ба тооны машин, цахилгаан гэрэл, дуутай кино (урьд нь дуугүй киного нэг удаа үзсэнсэн) энэ тэрийг бас анх удаагаа үзэх нь тэр.

Тэгээд хоршоодын холбооны 1952 оны тайлан гаргахаар ерөнхий нягтлан гуай, ах тэр хоёр явах болж намайг галч-тогооч бөгөөд бичиг данс хуулан бичигчээр 1953 оны өвөл дагуулж хот руу явсан юм. “ЗИС-5” хэмээх модон бүхээгтэй машинд олон авдар данснаас гадна хотод очоод хэрэглэх хүнс-хонины олон гулууз мах, шуудайтай гурил, цай, давс мэтийг ачаад намайг дээр нь гурван даханд хучиж суулгаад, мань хоёр жолоочтой гурвуулаа модон бүхээгэнд нь сууж Арвайхээрээс үдийн хэрд хөдлөж зууртаа хоёр унтаад гуравдахь хоногийнхоо шөнө нь хот орж ирэв. Одоо бол арваадхан цаг давхиад ирэх газар. Улаанбаатар хот гэдэг нь шөнийн харанхуйд алсаас гэрэл гэгээ цацраад л сүртэй гэдэг нь.

Дотор нь орж ирээд яваад л байдаг, яваад л байдаг, зах хязгаар гэж үгүй бололтой. Явж явж нэг айлын хашааг нүдэж сэрээгээд тэднийд хонов. Тэр айл одоогийн Гэсэр сүмээс зүүн хойхно, “Есөн гудамж” гэж байсны аль нэгэнд байсан байх. Маргааш өглөө нь аймгуудаас ирсэн хоршоодын холбоодын нягтлангуудыг байрлуулахаар консулын дэнж гэдэг газарт Хоршоодын төв холбооноос бэлдсэн нэг модон байшинд оров. Улаанбаатарт анх удаагаа орж ирж байгаа минь ч энэ, бас анх удаагаа байшинд байрлах болсон минь энэ билээ. Тэр байшингийн дэргэд нэг жижигхэн бор гэр байх аж.

Данс юмаа буулгачихаад ах, ерөнхий хоёр маань “Орой ирэхэд хоол хийсэн байгаарай” гэж даалгаад л явчихлаа. Биднийг Арвайхээрээс хүргэж ирсэн жолооч гуай “энэ айл их сургуулийн оюунтаных гэнэ, ээжээс нь чи одоохондоо ус авчраад цай чанаж бай, дараа нь ус ирэхээр тэднийд өгөөрэй” гэж байна.

Их сургууль гэж анх сонсоод тийм нэг сургууль байдаг байж гэж бодож байсан боловч “оюунтан” гэж хаанахын чухам хэнийг, юуг хэлээд байгааг өмнө нь сайн ойлгоогүй л явж байсан үе. Харин “улаан эрдэмтэн” гэж хүмүүс яриад байдгаас нь ном эрдэм их сурсан хүнийг л тэгэж нэрлэдэг байх гэж таамаглаж байсансан. “Оюунтан” гэж их мундаг амьтан байдаг байх, тэр “улаан эрдэмтэн” гээчийг бас ингэж нэрлэдэг юм болов уу, ер нь тэр их сургуулийн багшийг л “оюунтан” буюу “их ухаантан” гэдэг байх нь гэж бодсоор орвол “оюунтан” гуай нь алга, эрдэм номоо заах гээд явчихаж дээ гэж бодож байж билээ.

“Оюунтан” гээчийг харахсан гэж бодсоор орой нь нэг шалтаг олж тэднийд орвол мань “оюунтан” нь надтай үе тэнгийн бололтой залуу байх аж. Их сургууль гээчийн анагаахын салбарын оюунтан гэнэ. “Оюунтан” гээч нь над шиг амьтаныг тоож үг солихооргүй хүн байдаг байх гэж миний анх бодож байснаас тэс ондоон, их энгийн, яриа хөөрөөтэй хүү аж. Оюунтан гэгддэг хүмүүнийг ийнхүү анх удаагаа үзэж уулзаж байсан билээ.

Тэр үед “оюунтан” гэж яриад байсныг өнөө үед ухварлахуйд энэ үг “оюун ухаантан”, “оюун ухааны чадвартан” гэсэн утгатай, үнэхээр “оюунтан” гэсэн үг байсан байх, харин англиар student гэдэг нь ерөнхийдөө “сурагч”, “суралцагч”, “судлагч” гэсэн утгатай аж. Монголоор үүнийг “оюунтан” гэж орчуулдаг. Гэтэл энэ “оюунтан” гэсэн нэр томъёонд “оюун ухаан”, “оюун санаа” гэсэн утгыг илэрхийлсэн “оюунтан” гэсний дундах “н” нь алга болчихсон учраас сурах, мэдэхийн төлөө чармайгч биш, харин “ямар нэг юм эзэмшигч” буюу “ямар нэг юмтай хүн”, тухайлбал, “оюу хэмээх хөх юм уу ногоон өнгийн эрдэнийн чулуутай хүн”, “оюу эрдэнэтэй хүн”, “оюу эрдэнийн гоёлтой хүн”, эсвэл “танган тансаг гоёлтой хүн” гэсэн үг болсон мэт. Захирал Д.Цэвэгмид захирал гуай үг хэлэх бүрдээ заавал л “оюунтан” гээд байдаг байсан нь гайхмаар хачин сонсогддог байсан боловч тэр эрдэмтний болон энгүүн ардын “оюунтан” гэсэн хэллэгт ямар нэгэн үнэний учир утга байсан болов уу гэж санаж буйгаа биччихсэндээ дашрамд нь хүлцэл өчиж байна.

Тэднийд зарим оройд ороход тэр залуу намайг тоож надтай яриа хөөрөө болдог байлаа. Тэр залуу орос ном дэлгээд тавьчихсан уншиж байснаа хойш тавиад надаас юм асууж сонирхоно, надад юм ярина. Радио гэж манай аймагт байдагтай яг ижил далбагар хар юм нь ханын толгойд өлгөөстэй байгаа нь муухан шивнээд л, голдуу орос хэлээрх нэвтрүүлэг явдаг байлаа. Оросоор тэгж байна, ингэж байна гэж мань оюунтан надад тайлбарлана. Энэ залуу шиг эрдэм ном, орос хэл сурахсан л би гэж бодох. Тэгээд нэг орой тэднийд орсон чинь “Сталины бие муу байгаа” гэж зөвлөлтийн нэвтрүүлгээр хэлж байна гэлээ. Маргааш нь шиг санагдана, тэднийд орвол “Сталин үхлээ” гэж байна гэв. Энэ үе бол 1953 оны 3-р сар.

Хот үзээгүй би тэгэхэд гадуур явж мэдэхгүй, кино, ший, театр, цирк үзье гэхэд мөнгө санга ч үгүй, ах, ерөнхий хоёр ч юм үзэх, үзүүлэх

сөгөөгүй л нөгөө данс нийлэх ажлаараа яваад байх, ингээд надад зөвхөн гурил зуурч элдэж хоол, мах чанах, цай чанах, мод хагалах, хааяа явж нөгөө анх буусан айлдаа буулгасан гулууз махнуудаас үүрч ирэх ийм л ажил үлддэг байлаа. Сталиныг үхлээ гэж манайхан яаж байсныг би гадуур явдаггүй байсан болохоор юу ч үл мэднэ, бодвол манайхан “хөл, малгайгүй” гээч юм болж их л гашуудаж байсан байх.

Гулууз махыг шуудайд хийхлээр хүзүү тал нь илүү гарчихна, тэгээд би гэдэг амьтан нэг муу хуучирчихсан үнэгэн малгайтай, хөвөнтэй дээлтэй, эсгий гуталтай л “Есөн гудамж”-ны тэндээс “Өндөр хоршоо”, “До” яамны урдуур, засгийн газрын байшингийн баруун урд талд байсан нэг муу банзан хашаа-(тэр хашааг түшчихээд Д.Нацагдорж өөд болсон байсан гэнэлээ гэж хожим сонссон)-ны хойт өнцгөөр тойрч гараад Сүхбаатар жанжины хөшөөний урдуур төв талбайг ташуулдаж, төв театрын урдуур зүүн тийшээ зүтгэсээр америк дэнж өнгөрөөд консулын дэнж хүрдэг байлаа. Хэдэн удаа ингэж явахдаа ажиглавал над шиг муухай хувцас хунартай хөгийн амьтан миний замд ер тааралдахгүй байх аж.

Ингээд ичингүйрдэг болж, тэгээд замаа өөрчилж нэлээд хойгуур зүүн тийш анх удаа шинэ зам нээж явбал хүн амьтан арай цөөн мэт, сэтгэл тайвширч явж байтал олон баганатай том байшингийн урдуур гарах болдог юм байна. Нөгөө байшинг, Чойбалсангийн хөшөөг харан зогсож байтал тэр байшингаас олон залуучууд гарч ирэн бужигналдаад эхэллээ, намайг ажигласан хүн байсан уу үгүй юу, гэхдээ л өмссөн хувцас, мах үүрч яваа зэрэг ядмаг байдлаасаа ичингүйрч, сэтгэл зовж байж билээ. Ингэж Монгол улсын их сургуулийн байшинг анх удаагаа харсан минь энэ. Хожим хойчийн үед энэ сургуульд багш болно энэ тэр гэж яаж төсөөлөх вэ дээ, дэмий л гайхан биширч харж байсан минь тэр. Их сургууль маань тэр үед байгуулагдсанахаа 10 жилийн ойг өнгөрөөчихөөд 11 дэх жилийнхээ хичээлийг эхлэсэн үе байж таарна.

Дараа нь мах үүрэхдээ би “Есөн гудамж” гэдгээс бүүр их хойгуур, одоогийн 3 дугаар сургууль байгаагийн тэр хавиар гарч хүн амьтан цөөнтэй зэлүүд газраар зүүн тийш явсаар одоогийн “Манба” дацан байгаагаас арай урдуур хэдэн улаан байшингаас хойхнуур (тэр хэдийг зэвсгийн агуулах гэдэг байв) гарч буусан газартаа очдог болж билээ. Тайлан, баланс гээчээ мань хоёр гаргачихаад надаар баахан хүснэгтийг нэг шөнийн туршид тав таван хувь хуулуудад маргааш нь аваад явцгаалаа. Тэгээд хэд хоносны дараа буцах болж байгаа бололтой, машинаа аймгаас ирүүлэх гэнэ. Намайг гадуур дагуулж явж байгаад “Өндөр хоршоо” (одоогийн Дүрслэх урлагийн музей) гэдгийн дэргэд байгаа “Хоршооны Техникум”-ыг зааж, “Намар чи энэ сургуульд орно шүү, ирэхдээ төөрөхгүй олно биз” гэж байлаа.

Бас нэг баяртай үйл явдал тэр болов. Нөгөө айлаас мах авах гэж очих, ирэхдээ энэ “Өндөр хоршоо”-ны дэргэдүүр хэдэн удаа гарсан болохоор хожим нь энэ сургуулийг олоход түүртэхээргүй санагдаж байлаа. Тайлангаа гаргаад тушаачихсан учир бид нар 5-р сарын 1-ний өглөө Улаанбаатар хотоос гарч давхисаар байгаад шөнө 10 цаг болж байхад Арвайхээртээ ирж билээ. Өвөл гурав шахам хоног явж Улаанбаатар хот орж байсныг бодвол мөн ч түргэн явж харьсан даа.

Хувь заяаны тавилангаар миний бие Гучин-Ус сумын бага сургууль (1946-1950), Хоршооны техникум (1953-1956), Эрхүүгийн санхүү-эдийн засгийн дээд сургууль (1960-1964) энэ гурван их (буюу том) сургууль дүүргэсэн, бас Өвөрхангайн Хоршоодын холбоонд данс хөтлөгч (1952-1953), Дундговийн Дэлгэрхангай сумын хоршооны нягтлан (1956-1960) болж бүртгэл-тооцооны ажлын бага зэрэг туршлага эзэмшсэн, Худалдааны техникумын багш (1964-1970) болж хичээл заах дөртэй болсон зэргийн ачаар Монгол улсын их сургуульдаа 1970 оны 2 дугаар сарын 1-нд шилжин ирж нягтлангийн багш болсоноор олон эрдэмтэн олон багш нарын хичээнгүй хөдөлмөрт цуцал нэмэрлэж олон мянган залууст мэргэжил олгоход нь 43 жилийн туршид хүчин зүтгэхдээ Ширэндэв гуайн дараа нь болсон захирал Д.Цэгмэд гуай, Ж.Батмөнх гуай, Н.Содном гуай, О.Шагдарсүрэн гуай, Д.Дорж гуай, Ц.Ганцог гуай эдгээр эрдэмт мэргэдийн ивээлд багтаж, факультет, тэнхимийн хамт олныхоо халамж анхааралд явж ирсэнээ ихэд бахархан дурсах минь.

Ийнхүү товч дурсамж бичлээ. Гэхдээ эл богинохон өчилд миний ахуй амьдрал бүхэлдээ багтсан шүү. Хүмүүсийн дэмжлэгээр л би гэдэг амьтан өдий зэрэгт хүрчээ. Та бүхний минь эрдэм мэдлэг, буян хишиг, ажил хөдөлмөр, аз жаргал улам арвидан батжиж энх тунх байх болтугай! Та нар минь “Эвт шаазгай буга барина” гэдэг үгийг ямагт санаж, мөрдөж явууштай билээ.

Та биднийг төрийн минь сүлд өршөөх болтугай!